



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№111 /325/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.06.20

ХААНЫ ЭРЭЛД СУРГУУЛЬ ХААЛТАА ХИЙЛЭЭ



“Хааны эрэлд-2022” энхийг сахиулах ажиллагааны олон улсын хамтарсан сургуулийн хаалтын ажиллагаа өнөөдөр боллоо.

Тус ёслолын ажиллагаанд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, ЗХЖШ-ын Сургалтын бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны цэргийн атташе нар, бусад хүндэт зочид хүрэлцэн ирлээ.

Хаалтын ажиллагааг нээж Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай “Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа гүнээ ухамсарлаж, энх тайван, амар амгалан амьдралд тэмүүлж байгаа улс орон, ард түмэнд тусалж дэмжихийг эрмэлзэн, олон улсын энхийг сахиулах ажиллагаанд идэвхтэй оролцож цэргийн алба хаагчдаа илгээж эхэлснээс хойш 20 жилийг үдэж байна. Олон улсын түвшинд танигдсан энэхүү сургууль нь энхийг сахиулагчдад мэдлэг, дадлага, туршлагаа харилцан солилцож, энхийн төлөө үйлсэд журмын анд нөхөд болж,

цаашид хамтран үүрэг гүйцэтгэх боломж, нөхцөлийг бүрдүүлэн, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг билээ.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдлын улмаас сүүлийн хоёр жил тасраад байсан “Хааны эрэлд” энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургууль амжилттай зохион байгуулагдаж, өнөөдөр өндөрлөж байна. Энэ удаагийн сургуульд Монгол Улсаас гадна АНУ, Өмнөд Солонгос, Япон, Энэтхэг, ХБНГУ, Бангладеш, Малайз, Австрали, Швед, Франц, Турк, Канад, Сингапур, Балба зэрэг 15 улсын нийт 1000 гаруй цэргийн алба хаагчид ирж оролцлоо” хэмээн хэлсэн юм.

Сургалт, дадлагын хүрээнд орон нутгийг хамарсан болзошгүй хямралт цагийн байдалд НҮБ-ын цэргийн хүчнийг төлөөлөн үүрэг гүйцэтгэх олон үндэстний батальоны штабын ажиллагааг жигдрүүлэх команд штабын сургууль, тус штабаас гаргасан шийдвэрийг газар оронд гардан хэрэгжүүлэх салаадын хээрийн сургуулийг амжилттай явууллаа.

Мөн Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилгаар

“Эмэгтэй энхийг сахиулагчдын олон улсын бага хурал”-ыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд энэ удаагийн сургуулиар “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал” сэдвээр сургалт зохион байгуулагдсан нь энэ удаагийн сургуулийн яхын аргагүй онцлог үйл явдал байлаа.

Сургуулийн төгсгөлд Номхон далай дахь АНУ-ын Хуурай замын цэргийн командлалын командлагчийн орлогч дарга хошууч генерал Крис Смит “Хааны эрэлд” сургуулийн онцлог, ач холбогдлын талаар дурдаад, оролцсон нийт бие бүрэлдэхүүнд амжилт хүссэн юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 26	🌧️ 13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	🌧️ 25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,123.00	3,126.0
EUR 🇪🇺	3,290.0	3,305.0
CNY 🇨🇳	465.00	468.00
RUB 🇷🇺	50.10	50.50
JPY 🇯🇵	23.40	23.70
KRW 🇰🇷	2.46	2.48

ЗУРХАЙ

2022.06.20 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 22

ЗУНЫ ИЛҮҮ ТЭРГҮҮН САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХӨХ ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:
Идээ ундаа элбэг олдono
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
04.53-20.55
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Өтлөх үхэхүй
Суудал: Гэл

ҮБХИС, ДХИС-ийн ТӨГСӨЛТИЙН БАЯРЫН ЁСЛОЛ ХҮНДЭТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛЛОО



Өнөөдөр Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн 92, Дотоод Хэргийн Их Сургуулийн 88 дахь удаагийн хичээлийн жилийн төгсөлтийн баярын ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа Д.Сүхбаатарын талбайд боллоо. Ёслолын ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх болон Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, Засгийн газрын агентлагууд, ҮБХИС, ДХИС-ийн удирдлагын төлөөлөл, төгсөгчид,

төгсөгчдийн гэр бүлийн төлөөлөл оролцлоо.

2021-2022 оны хичээлийн жилд ҮБХИС-ийг нийт 370 орчим, үүнээс бакалаврын хөтөлбөрөөр 140 гаруй, мэргэжлийн боловсролын сургалтаар 230 орчим сонсогч, суралцагч төгсөж байна. Харин ДХИС-ийг нийт 1,000 гаруй, үүнээс бакалаврын хөтөлбөрөөр 600 гаруй, мэргэжлийн боловсролын сургалтаар 400 орчим сонсогч, суралцагч төгсөж байна. Ёслолын үеэр төгсөгчдөд “Сургууль төгсгөж, боловсролын зэрэг эзэмшүүлэх тухай” ҮБХИС, ДХИС-ийн захирлуудын тушаал, “Цэргийн цол олгох тухай” Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрийн цэргийн байгууллагууд, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа



агентлагуудын даргын тушаалыг уншиж танилцуулж, төгсөгчдөд цэргийн цол, мэргэжлийн диплом, энгэрийн тэмдэг гардуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхшилдэгтөгсөгчдөдэнгэрийн тэмдэг, диплом гардуулсныхаа дараа баяр хүргэж үг хэллээ. Тэрбээр үе үеийн шилдэг боловсон хүчнийг бэлтгэсээр ирсэн түүхэн замналтай ҮБХИС, ДХИС-аар овоглосон олон мянган төгсөгчид эх орныхоо өнцөг булан бүрт үг бүтээлтэй ажиллаж, Монгол Улсынхаа тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулан, төгссөн сургуулийнхаа алдар хүндийг дуурсган буйг тэмдэглээд “Эх орноо хамгаалах, аюулгүй байдлыг хангах эрхэм үүрэгтэй төрийн тусгай алба бол өөрийн гэсэн бахархал, нэр

хүндтэй, онцгой хариуцлагатай алба” хэмээн онцоллоо.

Мөн өнөөдөр сургуулиа төгсөж буй сонсогч, суралцагчид эзэмшсэн мэдлэг боловсрол, ур чадвараа эх орон, ард түмнийхээ сайн сайхны төлөө зориулах нэр төртэй бөгөөд хариуцлагатай үүргээ ямагт өндөрт өргөж явна гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлээд эх орныхоо тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдал, улс орон ард иргэдийнхээ амгалан тайван амьдралын төлөө зүтгэхээр тангараг өргөн сэтгэл шулуудаж, сургуулиа амжилттай төгсөж байгаа сонсогч, суралцагчдад болон гэр бүлд нь эрүүл энх, аз жаргал, ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөв.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 544,354,209

Эдгэрсэн

Нийт: 519,727,322

Нас барсан

Нийт: 6,340,915

Цахим шууданд

ТАВДУГААР ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ БОЛНО



Энэтхэг-Номхон далайн Хуурай замын цэргийн командлал болон Монгол Улсын Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал хоорондын V зөвлөлдөх уулзалт энэ сарын 22-24-ний өдрүүдэд Монгол Улсад болох гэж байна.

Зөвлөлдөх уулзалтад Монгол Улсын Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч хошууч генерал Б.Амгаланбаатар, штабын дарга хурандаа Д.Дугаррагчаа, ЗХЖШ-ын Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Ж.Молорболд нарын албаны бүрэлдэхүүн, АНУ-ын талаас Номхон

далайн Хуурай замын цэргийн орлогч дарга хошууч генерал Крисс Смит тэргүүтэй албаны төлөөлөгчид оролцоно.

Өнгөрсөн 4 жилийн зөвлөлдөх уулзалтаар хоёр улсын Хуурай замын цэргийн командлал хамтран олон зорилтыг хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд бие бүрэлдэхүүнийг чадваржуулан мэргэшүүлэх, инженерийн цэргийг хөгжүүлэх, цэргийн сургалтын орчин, материаллаг баазыг сайжруулах, бэхжүүлэх, хамтарсан дадлага сургуулийг зохион байгуулах зэрэг цэргийн хамтын ажиллагааны тодорхой чиглэлүүдийг амжилттай хэрэгжүүлж байгаа билээ.

“ЗУНЫ ЗУГААТАЙ БҮЖИГ” ХӨТӨЛБӨР ЭХЭЛЛЭЭ

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Ангийн захирагчийн тушаалаар 6 дугаар сарын 13-ны өдөр “Зуны зугаатай бүжиг” хөтөлбөр батлагдан алба хаагчдын хүүхдүүдийг бүртгэн авч сургалтаа эхлүүлээ.

Уг сургалт нь хүүхдүүдийг бага наснаас нь бүжгийн урлагаар хичээллүүлж, тэднийг оюун ухаан, бие бялдрын хувьд өв тэгш болгон төлөвшүүлэхээс гадна гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдалд ч эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм. Үүнээс гадна бүжгийн урлагийг дэлгэрүүлэх, зөв хандлагыг бий болгох, хүүхэд бүрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гоо зүйн мэдрэмжийг нь дээшлүүлэх, өв тэгш бие бялдрын хөгжилтэй, эрүүл монгол ирээдүйг бүтээх



эрхэм зорилго дэвшүүлэн амжилттайгаар хичээллэж байна.

Сургалт ангийн спорт зааланд явагдаж буй бөгөөд хүүхдүүд 3 сарын турш монгол бүжиг, чөлөөт бүжиг хосолсон ангид суралцах бөгөөд сар

бүрийн 28-нд сурсан бүжгээрээ шалгалт өгөх, сонирхолтой хөгжөөнт тоглоомууд, хөтөлбөрийн төгсгөлд эцэг эх, гэр бүлдээ тайлан тоглолтоор бэлэг барих юм.

Ахлагч Н.НАРАНДЭЛГЭР

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАА ЭРГЭЛЭЭ



өргөх ажиллагаанд нь оролцлоо.

Хоймор нутгийн залуус маань албан үүргээ үнэнчээр биелүүлж, эх оронч үзэл, цэргийн өдөр тутмын үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэн, хугацаат цэргийн албаа нэр төртэйгөөр хааж буйг Засаг дарга Ш.Идэрбаясгалан онцлон талархал илэрхийллээ.

Хошууч Т.АНХБАЯР

Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, эцэг эхчүүдэд цэргийн албыг сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор Увс аймаг дахь Хилийн цэргийн 0245 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж буй дайчдынхаа албаны үйл ажиллагаатай танилцаж, цэргийн тангараг



“СЭТГЭЛ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ БҮЛЭГ” БАГАГҮЙ АЖЛЫГ ТӨЛӨВЛӨЖ БАЙНА

Сэтгэл зүйн сургалт, судалгааны бүлэг нь “Сэтгэл зүйн оношилгоо, судалгаа”, “Сэтгэл зүйн

бие бүрэлдэхүүний оролцоонд суурилсан дасгал ажил, тоглоом, кейс хэлэлцэх, бүлэгт хувааж хэлэлцүүлэх зэрэг

тусламжтайгаар илрүүлж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлох, сэтгэл зүйн бэлтгэл хичээлийн чанар, үр дүнг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа явуулах, сэтгэл зүйн тусалцаа шаардлагатай цэргийн алба хаагчдад сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, улмаар сэтгэл зүйн боловсролыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, сэтгэл зүйн нөлөөллийн ажлуудыг бие бүрэлдэхүүнд зөвөөр ойлгуулахад чиглэгдэж буй юм.

Бэлтгэл ажлын хүрээнд цаашид Сэтгэл судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болон Улаанбаатар



сургалт, дадлага”, “Сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж” гэсэн үндсэн 3 чиглэлээр Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудад үйл ажиллагаа явуулах юм. Уг ажлын бэлтгэлийг Монгол Улсад сэтгэл зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн, багш нарын оролцоо, дэмжлэгтэйгээр шат дараалан хангаж байна.

Энэ хүрээнд сэтгэл зүйн оношилгоо, судалгааны ажлаар бие хүн өөрийгөө таньж мэдэхэд зориулагдсан сэтгэл зүйн EQ сэтгэл хөдлөлийн карт, МАК дотоод ертөнцийг нээх карт, өнгө, геометрийн дүрсээр хүн зурах, тоглоомын аргыг ашиглаж байгаа ба нийт бие бүрэлдэхүүнээс “Бие хүний харилцааг тодорхойлох”, “Мэргэжлийн сэтгэл ханамж”, “Социометр”-ийн судалгааг авч үнэлэлт, дүгнэлт өгөх юм.

Сэтгэл зүйн сургалт, дадлагын ажлаар “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн тогтвортой байдал” сэдвээр удирдлага, штаб, “Байгууллагын сэтгэл зүй, манлайлал”, “Сэтгэл зүйч гэж хэн бэ” сэдвээр нийт бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулж байгаа ба сургалтыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах үүднээс



олон талт үр дүнтэй аргуудыг ашиглаж байна.

Сэтгэл зүйн зөвлөгөө, тусламжийнажлаар сэтгэл зүйн бүлгийн болон ганцаарчилсан уулзалтыг зохион байгуулахад шаардлагатай арга зүйн хэлбэрүүдийг тодорхойлж, зөвлөгөөний жишиг боловсруулж “Стресс гэж юу вэ”, “Өөрийгөө таньж мэдэх нь” сэдвүүдээр бүлгийн зөвлөгөөг туршиж хэрэгжүүлжээ. Мөн ганцаарчилсан болон бүлгийн уулзалтын үед хөтөлгөх ЦАХ-ын хувийн картын загварыг боловсруулан ашиглаж байна.

Тус бүлгийн гол зорилго нь Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн байдалд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг сэтгэл зүйн сорил, судалгаа, оношилгооны

дээд сургуулийн Сэтгэл зүйн тэнхимийн судлаач, багш нартай хамтран ажиллах, “МЕТА” сэтгэл судлалын хүрээлэнд сэтгэл зүйн тренинг явуулахаар төлөвлөж байна.

“Сэтгэл зүйн сургалт, сурталчилгааны бүлэг” нь үндсэн үүргээс гадна сэтгэл зүйчийн ёс зүйг тодорхойлох, боловсруулах шаардлагатай гарын авлага, номын судалгаа хийх, сэтгэл зүйн сорил, судалгааны аппликейшн, веб хуудас бүтээх, сэтгэл зүйн судалгааны нэгдсэн цахим сан бүрдүүлэх ажлуудыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Ахмад Б.ЖАВХЛАНТӨГС

БЭЛТГЭЛ ҮҮРЭГТНҮҮДИЙГ ДАВТАН СУРГАВ

Зэвсэгт хүчний 014 дүгээр

Нийслэлийн Налайх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг ангийн байрлалд энэ сарын 12-16-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Сургалтад нэгдүгээр зэргийн 60 гаруй бэлтгэл үүрэгтэн хамрагдсан бөгөөд онол, дадлагын хичээлийг хослуулж, телеграфчин, сапёрчин тагнуулчин, тасалгачин сапёрчин, ерөмдөгч, жолооч зэрэг мэргэжлээр давтан бэлтгэгдсэн юм. Давтан сургалтын төгсөлтийн арга хэмжээ энэ сарын 17-ны өдөр зохион байгуулагдаж, Налайх дүүргийн ЗДТГ-ын дарга Ж.Алтангэрэл, Цэргийн штабын дарга, хурандаа Н.Энхбат, Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагч, хурандаа Г.Эрдэнэбаатар нар оролцлоо.



Энэ үеэр Налайх дүүргийн ЗДТГ-ын дарга Ж.Алтангэрэл “Монгол цэргийн тангараг өргөсөн та бүхэн эх орон дуудсан цагт хэзээд бэлэн байх ёстой хүмүүс. Тэр утгаараа цэргийн албанаас сурч мэдсэн эрдэм, мэдлэгээ үргэлж бататгаж байх нь нэн чухал. Та бүхнийг өөрсдийн мэргэжлийн

дагуу цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтад амжилттай хамрагдаж, их зүйл сурч мэдсэн гэдэгт итгэл дүүрэн байна” гээд сургалтад идэвх санаачилгатай оролцсон зарим байлдагчийг дүүргийн Засаг даргын нэрэмжит шагналаар шагналаа.

Дэслэгч Р.БИЛЭГ